# Шилэн дансны 2017 оны 2 дугаар улирлын тайлан

*2017.07.20*

# ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



# Хяналтыг дараах байдлаар хэрэгжүүллээ

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх
- - Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх
- - Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх

# Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхэд мөрдөж байгаа эрх зүйн акт

- Шилэн дансны цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын ЗГ-ын 2016 оны 01-р сарын 11-ний өдрийн 29 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай” тогтоол батлагдсан. Энэ тогтоолоор цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг журмаар зохицуулсан байна.

- **Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаарх авсан арга хэмжээ**
- “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилт, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, мониторингийн ажлын хүрээнд Шилэн дансанд мэдээлэл байршуулсан талаар бүх сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, Санхүүгийн албаны дарга болон бүх сумдын ИТХ-ын төлөөлөгч нарт сургалт зохион байгуулсан.
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд мэдээлэл хийж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын Зөвлөлд мэдээлэл хийж 2016 онд гарсан аймгийн Засаг даргын албан даалгаврыг эрчимжүүлэх захирамж тус тус гаргуулан хэрэгжилтийг тооцон ажиллахад эхний хагас жилийн байдлаар 1-р улирлын шилэн дансны тайланг Орхон сум, Стандарт хэмжилзүйн хэлтэс, 2-р улирлын тайланг нэг ч сум байгууллага ирээлээгүй байна. Энэ нь тогтоол шийдвэрийн хэрэгжүүлэх талаар хангалтгүй ажиллаж байгаагийн илрэл
- .

- Шилэн дансанд мэдээлэл мэдээлэх талаар зөвлөмж боловсруулан албан бичгээр Бүх сумдад хүргүүлсэн
- Булган сумын Хэсгийн ахлагч 50 гаруй хүнд хэлэлцүүлэг хийж асуумжаар судалгаа авахад шилэн дансны талаар анх удаа сонсож байна, мэдээллийг хаанаас авах талаар огт мэдлэггүй байна.
- Сангийн яам руу байгуулагуудын Шилэн дансны тайлан илгээсэн эсэх нь харагдахгүй байгааг уламжилснаар өнөөдрийн байдлаар Хорих 439 дүгээр анги, Нисэх, Хялганатын Үртсэн шахмал түлшний үйлдвэр, Хишиг-Өндөр сумын сумдундын эмнэлгийн шилэн дансны тайлан илгээсэн байдал харагдахгүй байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчдаас Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хялганатын тайлан илгээсэн байдал нь зураас хэлбэртэй болсныг Сангийн яаманд уламжилсан ч засагдахгүй хэвээрээ байна.
- Сар, улирлын эцэст мэдээлэл байршуулах байгууллага нэг бүрд мэдээллээ шивэх, тайлангаа илгээх талаар зөвлөгөө өгч байгаа

# Шилэн дансанд мэдээллээ байршуулаагүй дүн

| Үзүүлэлт | Төсвийн ерөнхийлөн захирагч | Төсөвт байгууллага | Тусгай сан | ЭЭС, ӨЭМТ | ОНӨААН | ТӨААН | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Мэдээлэл байршуулах байгууллагын тоо | 18 | 156 | 3 | 14 | 4 | 2 | 197 |
| Үүнээс мэдээллээ дутуу мэдээлсэн байгуул лагын тоо | 12 | 101 | 1 | 9 | 2 | 0 | 125 |
| Нийт дутуу мэдээлсэн мэдээллийн тоо | 26 | 274 | 3 | 13 | 7 | 0 | 323 |

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу 2017 оны 2 дугаар улиралд хийсэн хяналтаар батлагдсан төсвийг хугацаандаа байршуулаагүй, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан үзүүлэлтийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, сар, улирлын мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ тус бүрээр дутуу мэдээлсэн зөрчлүүд илэрсэн байна. Дээрх зөрчлүүдийг арилгуулахаар шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд хугацаандаа байршуулаагүй 126 байгууллагад албан шаардлага хүргүүлэхээр боллоo

# Мэдээллээ хоцроож мэдээлсэн байдал

| үзүүлэлт | Төсвийн ерөнхий лөн захирагч | Төсөвт байгуул лага | Тусгай сан | ЭЭС, ӨЭМТ | ОНӨААН | ТӨААН | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| хоцроо сон | 116 | 1039 | 2 | 361 | 87 | 16 | 1621 |

# Шилэн дансны нэгдсэн сайтад мэдээллээ бүрэн мэдээлсэн байдал

| үзүүлэлт | Төсвийн ерөнхий лөн захирагч | Төсөвт байгууллага | Тусгай сан | ЭЭС, ӨЭМТ | ОНӨААН | ТӨААН | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын тоо | 6 | 55 | 2 | 5 | 2 | 2 | 72 |
| нэрс | АЗД, Рашаант, Орхон, Хангал, Хишиг-Өндөр, Булган | | НДС, Халамжийн сан | Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Баян-агт, Бугат | Илчит хутаг ОНӨААТҮГ, Автотээврийн төв | Булган АЗЗАТӨ ХК, Булган МЭЭЖХ ХК | |

# Дүгнэлт

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгуулагууд мэдээллийн нэгдсэн цахим хуудсанд бүрэн байршуулсан байна.
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1,.3.1.2-т заасан 197 байгууллагаас 126 байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.6 мэдээллийг бүрэн оруулаагүй бөгөөд 97,6 хувьтай хуулийг хэрэгжүүлж байна.
- Орон нутгийн байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан
- Журмын дагуу мэдээллийг байршуулахдаа зарим байгууллагууд шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг хугацаа хожимдож оруулах, мэдээлээгүй зөрчил арилахгүй гарсаар байна.
- Бусад хяналт тавих эрх бүхий байгууллага хяналт тавихгүй байна.

# Санал

- Шилэн дансны тухай хуулийн 8.1-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ сум, багийн өөрөө удирдах байгууллагад сургалт зохион байгуулан арга зүйн зөвлөгөө өгөхөөс гадна шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.
- хуулийн 10.1-т заасан "Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
- Аймгийн төвийн байгууллагуудад нэгдсэн сайтаас гадна самбараар мэдээлсэн байдалд хамтарч хяналт тавих
- Сургалт, семинар зохион байгуулах